



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 7 сарын 7 өдөр

Дугаар 377

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ:

1.Хөдөө аж ахуйн их сургуулийн Ургамал газар, тариалангийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4,218,200.00 (дөрвөн сая хоёр зуун арван найман мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ, 2,946,877.88 (хоёр сая есөн зуун дөчин зургаан мянга найман зуун далан долоон төгрөг наян найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Хөдөө аж ахуйн их сургуулийн Ургамал газар, тариалангийн хүрээлэнгийн захирал Н.Баярсүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах,

2.2.Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг цаашид зориулалтын дагуу нөхөн сэргээж ашиглах,

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

132605731
19-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн
317 дугаар тогтоолын хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН УРГАМАЛ ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглал-тад орсон огноо	Нийт балансын үнэ	Нийт хуримтлагдсан	Үлдэх өртөг
				элэгдэл (төгрөг)	
1	4-н айлын сууц (Дархан-Уул аймаг дахь Хонгор сумын 1 дүгээр багт байрлах УГТХүрээлэнгийн бригад)	1980.01.01	4,218,200.00	2,946,877.88	1,271,322.12
Нийт дүн			4,218,200.00	2,946,877.88	1,271,322.12
			(дөрвөн сая хоёр зуун арван найман мянга хоёр зуун)	(хоёр сая есөн зуун дөчин зургаан мянга найман зуун далан долоон төгрөг наян найман мөнгө)	(нэг сая хоёр зуун далан нэгэн мянга гурван зуун хорин хоёр төгрөг арван хоёр мөнгө)